МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

2021 ENTREPRENEUR
САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭНТРЕПРЕНЕР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОВХИМОЛ

4-Р САР

2023 ОН


JIGUUR GRAND
GROUP Est. 1989
МАКС ӨРГӨӨ
TSAST
CONSTRUCTION
ЗАГ
ГРУПП
ERELT IMPEX
BASALTWOOL
МОНГОЛБАЗАЛЬТ ХК
Royal New Castle
RNC
ultrasonic
GERMAN QUALITY
NCD GROUP
НОГООН ИРЭЭДҮЙГ БҮТЭЭНЭ
NBK
UGUUJ KHISHIG CO.,LTD
БУТИ
ERCHIM ENGINEERING LLC
barilga.mn
БАТС-ӨРГӨӨ ХХК
T&G
MCS
property LLC
MONCON
MONGOLIAN CONSTRUCTION GROUP
ERIN
INTERNATIONAL
TESO
properties
DYNAMIC TOWER
SKETCH LLC
БАРМОН
АЛТАН ЖОЛОО
КОНСТРАКШН
VIP RESIDENCE
Valuable Innovative Peaceful
SD
ENGINEERING &
CONSTRUCTION
G.R.C
DOBU
BRIDGE
CONSTRUCTION
ISO 9001
ТУМ АРВИЖИХ
ЗАЙ ГҮЙГ БАРИЛГА ҮЙЛДВЭРЛЭЛ ХХК
УНИВЕРСУМ
ГРУПП
БОДЬ ИНТЕРНЭШНЛ
RENDERBAU
SERUUN
SINCE 1991
HIMON
CONSTRUCTION
InvesCore
СҮНДЭР ОРГОО ТРЕЙД ХХК
ОФФИС ПАРТНЕР
ChMM
construction
GANDIRS
DDMT
"ДИ ДИ ЭМ ТИ" ХХК
БУЯНПЭЛ ХХК
GREEN
RESOURCE
EFES GROUP
RELIABLE PARTNER...
ТАВАН БОГД ПРОПЕРТИ ХХК
Хөөтэн хуч - Амжилтын түлхүүр
NEW TELECOM
Pro Heat
Heating & Construction
ДАБЛЬ ПИРАМИД
КОНСТРАКШН
Ecological
Civil
Construction
АРГАЛАНТ АРВИС ГРУПП
RENDER
ЦАГААН ХУАРАН
КОНСАЛТИНГ
MINES UP
HOME
MORTGAGE
CORPORATION
ТЭНХЛЭГ ЗУУЧ
УЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
NATIONAL
N.A.P GROUP
BAGANAT URGUU
COMPANY
ULAANBAATAR
PROPERTIES
ТОПОЛОГИ ХХК
ЭРЧИМ ХҮЧ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ДЭД БҮТЭЦ
ХАЙРХАН ГРУПП
oly.mn
Mongolia's home of real estate
EUROIGI
ENGINEERING Co.,Ltd
НОМИН
МИШЭЭЛ
БЕТОН АРМАТУР ХХК
COMFORT IMPEX
ХУРД ГРУПП
ego
ENGINEERING & CONSTRUCTION
МОНГОЛ
АЛТАЙН ЦАГ
INTERNATIONAL
HYUNDAI
ELEVATOR MONGOLIA CO.,LTD
GOLDEN LIGHT
GROUP
МИШЭЭЛ
ГРУПП
MCS
estates
SOYOLC
ENGINEERIN
BUTANGUUD
CONSTRUCTION LLC
БАЯНСҮНДЭРЭЛ
ЦАГААН
ХӨШӨӨ
ТРЕЙД
BULDOORS MON
PERFECT DOOR SOLUTIONS
BOLD
"АТИМОС ТРЕЙД" ХХК
ЭВЭР ТУУРАЙ
PD
Solutions LLC
GLOBAL
ELECTRONICS
a GLOBAL NEGOEL Company
ХАНГАЙН ИЛЧ ДУЛААН ХХК
РАДИУС ХХК
БАРИЛГА, САНТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ
"AGGS" LLC
БОДЬЦОГТ ГРУПП
ЦАГААН УРАН ХИЙЦ
IG CON
ENGINEERING CONSULTANTS
BT Solution
MONGOL 333
CORPORATION
ZINDAA
CONSTRUCTION
Oortsog-Uul
Смарт Грийн
Девелопмент
VISION DEVELOPMENT LLC
A1
ARCHITECTS
ГУРВАН БУХАТ
ГРУПП
GLOBAL
TELECOM
БАЗУРА
ДИЗАЙН
АЛХ ХАДААС ХХК
BDMT
BUSINESS DEVELOPMENT & MANAGEMENT TEAM
HAPPY BUILDING LLC
ИХ МОДУН ХХК
UB GROUP
O&OCH LLC

ОРШИЛ

Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ нь өөрийн байгууллагын Эрхэм зорилго, зорилтын хүрээнд зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчимд нийцсэн барилгын салбарын тогтвортой байдлыг хангах, засаглалын зөв тогтолцоог бий болгох, салбарын эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан урт, богино хугацааны бодлогын болон стратегийн бичиг баримтыг боловсруулахад нөлөөлөх, суурь судалгааг хийх, салбарын чадавхыг сайжруулах чиглэлд салбарын яам, холбоод, иргэний нийгэм, гадаадын төсөл, хөтөлбөр болон олон улсын байгууллагуудтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн олон талаар хамтран ажилладаг билээ.

Дээрх эрхэм зорилго, зорилтын хүрээнд МБҮА ТББ-ын Ажлын алба нь 2023 оны 04 дүгээр сард хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, үйл ажиллагааныхаа тайланг байгууллагын “Стратеги төлөвлөгөө 2020-2024”-ийн зорилтын дагуу товхимол хэлбэрээр бэлтгэн хүргэж байна.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.1: УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖИЛ

2023.04.26: МБҮА ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРСАЙХАН НЬ “БИ БИ ВИ ИНТЕРНЕШНЛ” (BBW)-ТЭЙ АЖИЛ ХЭРЭГЧ УУЛЗАЛТЫГ ХИЙЛЭЭ



МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нь “БИ БИ ВИ ИНТЕРНЕШНЛ” (BBW) Сургалтын төвийн менежер Аника Брум, “Архитектур+” ХХК-ийн Захирал, Архитектор Үвэ Фикэншэр нартай 2023.04.26-ны өдөр ХБНГУ-ын Хоф хотноо ажил хэргийн уулзалтыг хийж, хоёр байгууллагын ойр ба дунд хугацааны хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй ярилцлаа. ХБНГУ-ын Баваари мужийн “БИ БИ ВИ ИНТЕРНЕШНЛ” байгууллага болон Архитектор Үвэ Фикэншэр нар нь 2023.06-р сард Монгол Улсад зохион байгуулагдах IFAWPCA-ийн 42 дахь Дунд хугацааны чуулганы “Тогтвортой барилгын эрин Олон Улсын форум” Олон улсын форумд оролцох IFAWPCA-ийн гишүүн орнуудын болон Монголын талын оролцогчдод зориулан ХБНГУ-ын Хоф хотноо байрлах “Нарны байшин”-д хэрхэн нар, дулааны сэргээгдэх эрчим хүчийг ашиглан эрчим хүчээр хангаж буй технологийн шийдлийг танилцуулж, туршлагаасаа хуваалцах юм. Өнгөрсөн 2022.10-р сард BBW байгууллага болон МБҮА ТББ нь Монгол Улсын техникийн их сургууль, салбарын бусад холбоодтой хамтран төвлөрсөн бус эрчим хүчний эх үүсвэрээр барилга байгууламжийг хангах технологийг Монгол Улсад нутагшуулах туршилтын төслийг (Pilot project) 2023 оноос эхлүүлэхээр тохиролцсоны дагуу уг төслийн саналын санхүүжилтийн хүсэлтийг Баваари мужийн Эдийн засаг, эрчим хүчний яаманд тавьж, улмаар дараагийн алхмууд хийгдэж байгааг мэдэгдсэн болно. Хоёр байгууллага нь хамтын ажиллагааны ажлуудаа үргэлжлүүлж ирэх 2023.09-р сард “БИ БИ ВИ ИНТЕРНЕШНЛ” (BBW)-ийн техникийн семинарыг ХБНГУ-д зохион байгуулахаар болж, үүнд Монголын талаас МБҮА ТББ-ын гишүүн байгууллагуудаас 18 төлөөлөгчийг оролцуулахаар тохирлоо. Архитектор Үвэ Фикэншэр болон МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нар нь Монгол Улсад төвлөрсөн эрчим хүчний системээс үл хамаарсан сэргээгдэх эрчим хүч, түүний дотор нарны эрчим хүчийг ашигладаг барилгыг барих олон давуу тал байдгийг онцолж, жилийн нийт өдрүүдийн 80 хүртэлх хувь нь нартай байдаг, барилгын дулаалгад байгалийн гаралтай хонины ноосны дулаалгын болон бусад барилгын материалыг ашиглах боломжтой байгаа, мөн ХБНГУ-ын Hi-tech Engineering технологийг Монголын сэргээгдэх эрчим хүчний нөөц болон түүхий эдийн онцлогтой хослуулах технологийг боловсруулж, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, судлах зэрэг асуудлыг цаашид судалсны үндсэн дээр хамтран ажиллахаар боллоо.

2023.04.04: “БАРИЛГЫН САЛБАРЫН СЭРГЭЛТ” ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР САЛБАРЫНХАН ЧУУЛЛАА



“Хөгжлийн төлөө барилгачдын нэгдэл” ТББ-аас зохион байгуулсан “Барилгын салбарын сэргэлт” хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, БХБЯ-ны газрын дарга Д.Гантулга, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын Захирал Ц.Амарсанаа нар урилгаар оролцлоо. Хэлэлцүүлгийн гол зорилго нь өнгөрсөн 2020 оны нэгдүгээр сараас дэлхий нийтийг хамарсан цар



тахлын улмаас хил хаагдаж, монголын барилгын салбарт материалын хомсдол үүсэж, үнэ өссөн, үүнийг дагаад барилгын салбарынханд болоод төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэгч компаниудад багагүй асуудал тулгарсан, иймээс барилгын компаниудын төлөөллүүд нэгдэж Засгийн газар, салбарын төрийн байгууллагуудад хандаж үг, үзэл бодлоо нэгтгэн хүргэхэд оршсон болно. Хэлэлцүүлгийн гол сэдэв нь салбарын төрийн байгууллагууд болон барилгын компаниуд нь нэгдэж цаг үеийн хүнд нөхцөл байдлыг даван туулж, Улсын Их Хурлын 2021.11.12-ны өдрийн 88 дугаар тогтоолыг батлуулж чадсан болж үр дүнгийн асуудал байв. Тодруулж хэлбэл, барилга байгууламжийн төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, үнийн өөрчлөлтийн индексийг батлах, Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт магадлал хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан. Тиймээс 634 төсөл, арга хэмжээний 301.2 тэрбум төгрөгийн үнийн зөрүүгийн санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны улсын төсвийн тухай хуульд тусгуулж чадсан. Цаашид Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа төсөл хөтөлбөрүүдийн чанарын асуудал, газар хөдлөлтөд тэсвэрлэх норм стандартыг баримталж ажиллах, хүний нөөцийг чадавхжуулах тал дээр анхаарах шаардлагатай байгаа зэрэг асуудлыг төрийн байгууллагуудаас анхааруулсан юм.

2023.04.12: МБҮА ТББ-ЫН ДҮРМИЙГ ШИНЭЧЛЭХ, АЖЛЫН АЛБАНЫ БҮТЦИЙГ ӨӨРЧЛӨХ “АЖЛЫН ХЭСЭГ”-ИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛЛОО

МБҮА ТББ-ын “ДҮРЭМ”-ийг шинэчлэх, АЖЛЫН АЛБАНЫ БҮТЭЦ-ийг өөрчлөх зорилгын хүрээнд МБҮА ТББ-ын Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар-р ахлуулсан “АЖЛЫН ХЭСЭГ”-ийн ээлжит уулзалт 2023.04.11-12-ны өдрүүдэд цахимаар боллоо. Уг хуралд МБҮА ТББ-ын Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, Дэд ерөнхийлөгч Б.Чимэгцэцэг, УЗГ С.Батболд, Н.Цогтоо, Г.Эрдэнэчимэг, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан, Хуулийн зөвлөх Б.Сумъяажав, Салбарын бодлого хариуцсан зөвлөх Г.Лосол, Үйл ажиллагаа хариуцсан менежер Х.Долзодмаа, Нягтлан бодогч Мөнхчимэг, Гишүүнчлэл, маркетинг хариуцсан менежер Х.Намуун нар оролцож саналуудаа тусгалаа. 14 хоногийн дараа нэгтгэлийг танилцуулж сүүлийн хурлыг хийхээр тогтлоо.

2023.04.12: МБҮА ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД ЧӨЛӨӨТ УУЛЗАЛТ ХИЙВ



МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Дэд ерөнхийлөгч “Эко констракшн” ХХК-ийн захирал С.Нямдаваа, “Номин констракшн девелопмент групп” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Хүрэлхүү нарт МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын нийгэмлэг (IFAWPCA)-ийн 42 дахь удаагийн Дунд хугацааны хурлын хөрөнгө оруулалт, бэлтгэл ажлын талаар танилцуулж холбогдох чиглэлийг авч ажиллалаа.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.3: БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛ

2023.04.14: МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ОЙЛГОМЖГҮЙ БАЙДАЛ ХҮНДРЭЛ УЧИРЧ БУЙ САНАЛЫГ НЭГТГЭН ЗГХЭГ-Т ХҮРГҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл, эрх зүйн орчны ойлгомжгүй байдал, оновчгүй зохицуулалтын талаарх санал асуулгыг МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагуудын дунд явуулсны үр дүнд саналуудыг хүлээн авч нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүллээ. Уг саналуудын дийлэнхэд нь хууль, эрх зүйн баримт бичгийн ойлгомжгүй байдал, оновчгүй зохицуулалтын улмаас бизнес эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээлүүдэд нэн тэргүүнд шинээр батлагдан хэрэгжиж буй “Хөдөлмөрийн тухай” хууль орж байгаа юм.

Хөдөлмөрийн тухай хуулийн оновчгүй заалтуудын улмаас бизнес эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл:

- *Уртын ээлжийн горимоор ажилладаг ажилтны ээлжийн амралтын хугацааг тооцон гаргахад холбогдох журмын зохицуулалт зөрчилдөж* байгаа ба харин *ээлжийн амралтын хугацаа болон цалинг тухайн ажилтны ажлын жилийн ажилласан цагт нь тооцдог байвал ажилтнуудад нэг стандартын зохицуулалтыг бариmтлан хэрэгжүүлэх боломжтой байгаа*
- *Гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь мэргэжлийн зөвлөх түвшний нарийн мэргэжлийн мэргэжилтэн байдаг* тул хуулийн 14 хоног ажиллах, 14 хоног амрах хуваарийг баримтлах боломжгүй бөгөөд тус зохицуулалтыг *Гадаадын иргэний хувьд уян хатан байдлаар харилцан тохиролцох нөхцөлтэй болгох нь илүү бодит байдалд хэрэгжүүлэх боломжтой* байгаа
- *Хугацаагүй хөдөлмөрийн гэрээг төсөл хэрэгжүүлж байх хугацаанд байгуулах боломжгүй* бөгөөд бодит байдалд ажлын байр нь төслийн үйл ажиллагаагаар хязгаарлагддаг байгууллагын хувьд иргэнд ажлын байрыг санал болгох нөхцөлийг хязгаарласан
- Ажиллах хүчийг нийлүүлэх гэрээгээр харилцан хамаарал бүхий хуулийн этгээд нь сул зогсолт эсхүл ажиллах хүчний хомсдолд орсон үед өөр хоорондоо ажиллах хүчээр хангах нөхцөлийг хязгаарласан ба “Хөдөлмөрийн тухай” хуульд Ажиллах хүчийг нийлүүлэх, гэрээгээр авч ажиллуулах ажилтны тоо нь хүлээн авагч талын нийт ажилтны 30 хувиас хэтрэхгүй гэж заасан нь харилцан хамаарал бүхий хуулийн этгээдүүд нь хүн хүчээ өөр хоорондоо хангах боломжийг хязгаарлаж байгааг хүчингүй болгох
- *Мөн уртын ээлжээр ажиллах зохицуулалт нь зөвхөн уул уурхай, олборлох салбарын ажил олгогчид хэрэгжүүлэх боломжтой байгаа нь бусад салбарт үйл ажиллагаа эрхэлдэг салбар нэгжийг хязгаарлаж байгаа*

Зохион байгуулалтын оновчгүй байдлын улмаас бизнес эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээл:


- Бүх бичиг баримтаа бүрэн өгөх, хүсэлтээ өгөх, түүний хариу, саналыг авахад төрийн байгууллага нь хуульд заасан цаг хугацаандаа гаргаж өгөхгүй, тодорхой хариу, шалтгааныг өгч чадахгүй, энэ асуудлаас болж компанийн хэвийн үйл ажиллагаа саатах
- Холбогдох утасны дугаар нь ажиллахгүй эсхүл холбогдох боломжгүй байдгаас биечлэн очих шаардлага гарах, цаг хугацаа алдагдах
- Байгууллагад мэдэгдэхгүй газрын ашиглалтыг өөрчлөх, уг шийдвэрээс болж их хэмжээний газрын төлбөр төлж, газраа зориулалтын дагуу ашиглах боломжгүй болох

- Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын гүйцэтгэгч нар нь тогтмол өөрчлөгдөж, хэрэг нь тодорхойгүй хүн рүү шилждэг ба шинээр хүлээж авсан гүйцэтгэгч нь хэрэгтэй шинээр танилцах гэж хугацаа ордгоос чирэгдэл үүсгэх
- УИХ-ын 88-р тогтоолд царцчихсан байгаа 1,100 төсөлд *төсөвт өртгийн магадлалыг хийх гэсэн тогтоол* гарсан. Хэрэгжилт дээрээ Барилга, хот байгуулалтын Сайдын 75-р тушаалаар *зөвхөн материалын магадлан хийгдсэн*. Гэтэл барилга барихад шууд гардаг 4 зардал бий, үүнд: *цалин, материал, тээвэр, машин механизм* гэсэн *зардлын үнэ бүгд өсчихсөн* байгаа тохиолдолд зөвхөн материалын үнийг магадлаад нэмэргүй. Цаашдаа *тухайн барилгыг зөвхөн материалын үнийн өсөлтөд олгосон мөнгөөр нь барих боломжгүй болгочхож байгаа*
- Төрийн шийдвэрүүд нь бизнесийн хурдыг гүйцэж гарахгүй байгаа учраас 630 гаруй компани нь дампуурлын ирмэгт хүрчхээд байна. Дээрх компаниуд нь бүгд татвар, НДШ-ийн өртэй тул дансыг нь хаачихсан байгаа,


Төрийн байгууллагын тогтолцоог өөрчлөх нөхцөл байдал:

- Парисийн хэлэлцээрийн зорилтыг хангахын тулд ЗГ-ын өнөөгийн бүтэц, зарим яамдуудыг чиг үүргээр нь эрэмбэлэн нэгтгэх байдлаар өөрчилж, НОГООН ХӨГЖИЛ, ДЭД БҮТЦИЙН ЯАМ нэрийн доор нэгтгэх, төсөв санхүүг хэмнэх, мэргэжлийн чадамжит багаар хөгжлийн оновчтой загварчлал бүхий томьёоллыг боловсруулах
- Зарим тохируулах чиг үүрэгтэй агентлагуудыг чиг үүргээр нь нэгтгэж санхүүжилтийн босоо тогтолцоог өөрчилж, бие даасан байдлаар хөгжих боломжийг бүрдүүлэх
- Төр-хувийн хэвшлийг холбосон ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН оролцоог салбар бүрээр нэмэгдүүлэх, ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ шилжүүлэх, хуульчлах, хөгжлийн загвар моделиудыг турших, үр дүнг түгээн дэлгэрүүлж сурталчлах
- Бүх салбарт орчин цагийн ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИУД дээр суурилсан системийн шинэчлэлийг яаралтай хийж, эдийн засгийн өрсөлдөх чадамжийг нэмэгдүүлэх
- Бүх салбарт хөгжлийг хурдасгах гол хөшүүрэг бол ӨНӨӨГИЙН ЗАСАГЛАЛ-ын тогтолцоог өөрчлөх явдал. Тухайлбал, аймгуудын уурын зуухыг Аймгийн Засаг даргын мэдлээс холдуулж, эрчим хүчний салбарын харьяалалд авчрахгүйгээр ЗГ-ын 144-р тогтоолын хэрэгжилт нь биеллээ олохгүй болно. Өөрөөр хэлбэл, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧИЙГ ХЭМЖҮҮРЭЭР ТООЦОХЫГ төрийн статус бүхий хангагч байгууллагууд нь өөрсдөө эсэргүүцнэ гэдэг бол дэлхийд байхгүй үзэгдэл
- МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЯАМДУУДЫГ ЭРЭМБЭЛЖ нэгтгэх, АГЕНТЛАГУУДЫГ эмхлэх, ХОРОО ХОРИН БА АЙМАГ, СУМДЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖҮҮДИЙН бүтцийг ЭРС ШИНЭЧЛЭХ талаарх саналуудыг нэгтгэж төрийн байгууллагаас гаргаж байгаа АЛИВАА ШИЙДВЭР, ЖУРАМ, ЗОХИЦУУЛАЛТ НЬ БИЗНЕСИЙН САЛБАРУУДАД ЭЭЛТЭЙ, ОЙЛГОМЖТОЙ БАЙХ ТАЛ ДЭЭР АНХААРЧ АЖИЛЛАХ зэрэг саналуудыг нэгтгэлээ.

2023.04.25: МҮХАҮТ дээр энэ өдөр “Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны барилгын шинэ дэвшилтэт технологийг баталгаажуулах, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж, санал боловсруулах уулзалт” зохион байгуулагдаж, МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн болно.



2023.04.05: БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАХ ХҮЧИНГ ИДЭВХЖҮҮЛЭХ, ЧАДАВХЖУУЛАХ АСУУДАЛ ТУЛГАРЧ БАЙНА



Барилгын салбарт тулгамдаж буй ажиллах хүчинг идэвхжүүлэх, чадавхжуулах, түүнд шаардагдах санхүүгийн болон санхүүгийн бус байдлаар хэрхэн дэмжин ажиллах боломж бололцооны талаарх санал бодлоо солилцох зорилгоор Азийн сангийн “Эмэгтэйчүүдийг дэмжих, чадавхжуулах хөтөлбөр”-ийн Дэд менежер н.Цолмонтой МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан, МБҮА ТББ-ын Гишүүн, “Эн Эй Пи Групп” ХХК-ийн захирал М.Уянга болон Ажлын албаны Гишүүнчлэл, маркетинг хариуцсан менежер Х.Намуун нар цахим уулзалт хийлээ. “Эн Эй Пи Групп” ХХК-ийн Захирал М.Уянга нь: Барилга, барилгын зураг төслийн компаниудад зургийн, цахилгааны, халаалт агаар сэлгэлтийн инженерүүдийн эрэлт 621 байгаа бол тус мэргэжлээр жилд 18-45 хүн төгсөж байгаа талаар дурдлаа. Салбарын хүний нөөцийн хомсдлыг өнгөрсөн жилээс судлан, нийлүүлэлтийг ихэсгэхээр “Эн Эй Пи групп” ХХК нь өөрийн компанийн санхүүжилтээр үе шаттайгаар ажиллаж байгаа ба зорилгын хүрээнд тухайн чиглэлээр сурч буй оюутнуудын дунд тэтгэлэг зарлаж байгаа бөгөөд инженерийн мэргэжлийг таниулах, сурталчлах, туршлага солилцох өдөрлөгийг зохион байгуулахаар бэлтгэлээ хангаж байна. Энэ арга хэмжээг цаашид үргэлүүлэхийн тулд дан ганц компани бие дааж хийхэд санхүүгийн бэрхшээлтэй байгаа тул энэ асуудлыг дэмжих тал дээр цогц бодлогыг боловсруулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай байгаагаа илэрхийлсэн юм.

АС-ийн “Эмэгтэйчүүдийг дэмжих, чадавхжуулах хөтөлбөр”-ийн Дэд менежер н.Цолмон: АС-ийн Олон улсын ТББ нь нийгмийн тэгш бус байдлыг арилгах, ардчиллыг бэхжүүлэх, тэгш нийгмийг бүрдүүлэх, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төслийг 2024 он хүртэл хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд эмэгтэй бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдгээрийг чадавхжуулах сургалтад бүрэн хамруулах боломжтой байгааг илэрхийлэхийн зэрэгцээ салбарт тулгамдаж буй ажиллах хүчийг дэмжих, түүнийг нэмэгдүүлэхэд шаардлагатай байгаа санхүүгийн боломж бололцоог хаанаас, ямар газруудтай холбогдон хамтран ажиллаж авч болох боломжтой байгаа талаар зөвлөгөө, мэдээ мэдээллийг өгсөн юм.

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилтын хүрээнд холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд 2023.04-р сард “Эндлэсс Энержи ХХК, “Мандалт констракшн” ХХК зэрэг байгууллагуудыг шинээр элсүүлсэн бол “Дулаан шийдэл” төсөлд 2020 оноос хойш чадавхжиж, хамтран ажиллаж буй Төслийн Бригадын ахлагч С.Батнасан-г Дэд гишүүнээр элсүүллээ.



“OPEN WEEK” буюу “Байгууллагын 7 Хоног” аяны хүрээнд МБҮА ТББ-ын Гишүүн “ЧОКВАНГ ПЭЙНТ МОНГОЛИА ХХК нь 2023.04.27-ны өдөр “НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ”-ийг ТИТАН худалдааны төв дахь салбартаа зохион байгуулж, барилга байшинд хэрэглэж буй будаг нь хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа талаар АУШУИС-ийн багш, доктор П.Нарангэрэлээр дотоод орчны аюулгүй байдлын талаар танилцуулгыг хийлгүүлж, “ЧОКВАНГ ПЭЙНТ МОНГОЛИА ХХК-ийн Менежер Э.Цэрэнпүрэв нь оруулан ирж буй бүтээгдэхүүний чанар, стандартын талаар мэдээлэл өгсөн юм.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.3: БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛ

“ДУЛААН ШИЙДЭЛ-2” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ

2023.03.31-04.03: “УЛААНБААТАР БАРИЛГА ЭКСПО 2023”-Д ОРОЛЦЛОО

2023.03.31-04.03-ны хооронд Мишээл экспо төвд “Улаанбаатар барилга-2023” үзэсгэлэн зохион байгуулагдаж, МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл-2” төслийн баг болон бригадууд эрчим хүчний хэмнэлт, дулаалгын чиглэлээр мэдээ мэдээлэл өгөхийн зэрэгцээ төслийн үйл ажиллагаагаа сурталчлан оролцлоо. Нийт 14 дулаалгын зөвлөх, бригадын ахлагчид үзэсгэлэнд оролцож, нийт 880 ширхэг төслийн брошюр болон төслийн 1, 2-р үе шатны үр дүнг харуулсан танилцуулга хуудсыг тарааж, зөвлөгөө зөвлөмжүүд өгч ажиллан харилцагчдаас нийт 39 ТҮ-ний захиалгыг бүртгэн авав. Мөн ТҮ-ний захиалга өгсөн харилцагч нарын дунд Асуулт, хариултын тэмцээнийг явуулж 3 азтаныг шалгаруулж төслийн гарын бэлгийг гардуулж өгөв.







2023.03.31: “БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ” СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



2023.03.31-нд “Дулаан шийдэл-2” төслийн 1, 2-р элсэлтийн нийт 38 бригад нь “Барилгын хог хаягдлын менежмент” сэдэвт сургалтад хамрагдаж, барилгын хог хаягдал ба норм, дүрэм стандарт, мөн барилгын амьдралын мөчлөг ба барилгыг буулгах шалтгаан, буулгалтын хог хаягдлын менежмент болон төслийн дулаалгын ажлын үед гарах барилгын хог хаягдалын менежментийн талаар бригадуудад сургалт оров. Түүнчлэн сургагч багш Д. Сүнжидмаа нь Төслийн үйл ажиллагаанд хог хаягдлын менежментийг нэвтрүүлэх тал дээр зөвлөмж өгч, МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл” төслийн багтай цаашид хамтран ажиллахаар зөвшилцөв.








2023.04.03-04: “БАРИЛГЫН ДУЛААН ХАМГААЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ” СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

“Дулаан шийдэл-2” төслийн шинэ элсэлтийн БЖДБЭ буюу 2-р ээлжийн шинэ бригадуудад зориулсан “Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ” сургалтыг 2023.04.03-04-ны өдрүүдэд БЭХХТ-тэй хамтран зохион байгуулав. Уг 2 өдрийн сургалтад нийт 25 шинэ элсэлтийн бригадууд хамрагдаж “Дулаалгын өртөг тооцоолол”, ногоон зээлийн танилцуулга болон "Дулаан шийдэл" вэ системийн хэрэглээний зааварчилгаа, дадлагын ажлуудыг хийж, байшингийн дулаан алдагдлыг хэрхэн хэмжих, тооцоолох болон техникийн бичиг баримтууд болон үнэлгээний маягтыг веб системд хэрхэн бөглөх талаар суралцав. Цаашлаад, төслийн “Технологийн болон барилгын дулаан хамгаалалтын үнэлгээний” сургалтад бүрэн хамрагдсан 2-р ээлжийн бригадуудыг үе шаттайгаар дадлагажуулж, төслийн 4 туршлагатай дулаалгын зөвлөх 16 шинэ хүнийг 26 удаагийн техникийн үнэлгээний дадлагад гаргаж байна. Ирэх 14 хоногт энэ нь үргэлжлэх бөгөөд дадлагажуулсан дулаалгын зөвлөхүүдэд мөн урамшууллыг тооцон олгох юм.

2023.04.19: ТӨСЛИЙН САР ТУТМЫН МАРКЕТИНГ, ТЕХНОЛОГИЙН УУЛЗАЛТ БОЛОВ




2023.04.19-нд “Дулаан шийдэл-2” төслийн сар тутмын ээлжит онлайн уулзалтад 30 орчим дулаалгын зөвлөх, бригадын ахлагчид оролцлоо. Уулзалтаар тухайн сард болох товлогдсон арга хэмжээнүүд болон тухайн цаг үеийн талаар, мөн төслийн шугамаар дулаалгын ажил гүйцэтгэхдээ зайлшгүй нөхцөлд “хэрэглэгчийн хүсэлт”-ийг харгалзаж үзэх, буруу, дутуу зөвлөгөө, мэдээлэл, үнэлгээ гаргахаас зайлсхийж төслийн багтайгаа нягт хамтран ажиллаж төслийн инженерүүдийн зөвлөмжийг дагах талаар мэдээ, мэдээллүүдийг өгөв. Түүнчлэн, төслийн шугамаар ирсэн харилцагчтай хувиараа тохирч ажил гүйцэтгэх эсвэл өөрийн харилцагчдаас төслийн технологиор техникийн үнэлгээ, дулаалга хийх бол тухай бүрд нь төслийн багт мэдээлж байх талаар сануулав. Ингэснээр төслийн гүйцэтгэлийн үнэлгээ нь өндөрсөж, урамшуулал авах магадлал нь нэмэгдэх юм.

ТӨСЛИЙН ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХ БОЛОН БРИГАДЫН АХЛАГЧДЫН KPI НЭГТГЭЛИЙГ ГАРГАВ

2022.11-2023.03-р сар хүртэл буюу нийт 5 сарын байдлаар KPI нэгтгэлийг гаргалаа. Үнэлгээнд сард ба түүнээс дээш техникийн үнэлгээ хийсэн, 1-5-р саруудад ажилласан 15 дулаалгын зөвлөх, бригадын ахлагчийг хамруулсан бөгөөд 5-н сарын дундаж үзүүлэлт нь 82%, 46 оноотой байна. Одоогоор Бригадын ахлагч Ц.Цогт-Эрдэнэ 1-т жагсаж байна. 2023.05.15-ны долоо хоногт болох Санхүүгийн мэдлэг олгох, бригадууд хоорондоо нэтворкинг үүсгэх, шинэ хүмүүстэй Санамж бичиг зурах, туулкит гардуулах арга хэмжээн дээр KPI-н шагналыг гардуулахаар төлөвлөж байна.

2023.04.21: МАРКЕТИНГ БОРЛУУЛАЛТЫН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



“Дулаан шийдэл-2” төслийн шинэ буюу 2-р ээлжийн бригадуудад зориулсан хагас өдрийн Маркетинг, борлуулалтын сургалтыг Жэрэс ОУТББ-тай хамтран 2023.04.21-нд зохион байгуулав. Тус сургалтад нийт 15 бригад оролцож төслийн хэрэглэгч нарт санал болгодог дулаалгын бүтээгдэхүүнүүд болон борлуулалт хийх аргачлал, ногоон зээлийн нөхцөл, шаардлагын талаарх танилцуулга, цаашлаад бригад болон дулаалгын зөвлөхийн төсөлд гүйцэтгэх үүрэг хариуцлагын талаарх мэдлэг мэдээллийг авав.

2023.04.14: “РОСТОРГ” ХХК-ИАС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТУУДАД БРИГАДУУДЫГ ХАМРУУЛАВ

“Дулаан шийдэл-2” төслийн нийт 10 дулаалгын бригад нь төслийн хүрээнд хамтран ажилладаг “Росторг” ХХК-иас 2023.04.14-нд зохион байгуулсан “KNAUF эрдэст хөвөнгөөр хэрхэн дулаалга хийх” сургалтад амжилттай хамрагдаж батламжаа гардан авав. Үргэлжлүүлэн, 2023.04.27-нд “Росторг” ХХК-аас зохион байгуулагдсан “Шинглас дээврийг хэрхэн хийх” сургалтад нийт 13 дулаалгын бригадыг хамруулав.



Мөн түүнчлэн, МБҮА ТББ-ын Дулаан шийдэл-2” төслийн баг нь 4-р сард:

- Барилгын ажлын цахим системийн хөгжүүлэлтийн ажлын хүрээнд: ДАН, ХУР систем, Mailgun, QPay-тай тус тус холболт хийж, тус цахим системийн Логог зуруулан хүлээж авав.
- 04.28-нд I, II элсэлтийнхэнд Жэндэрын сургалтыг хамтран хэрэгжүүлэгч байгууллага болох МОНЭС-ийн санхүүжилттэйгээр хийхээр тохирч, тус сургалтад 20-25 хүн оролцуулахаар болов.
- 04.28-нд “Төслийн хөндлөнгийн зөвлөх хороо”-ны хуралд Төслийн удирдагч, Гүйцэтгэх захирал Л.Хулан болон Дулаалгын зөвлөхүүдийг төлөөлж, Л.Цэеэрэгзэн, Ж.Өнөрбаяр нар оролцов.
- Төслийн санхүү, семинар, бусад хурал цуглаанд багаараа оролцов.

ТӨСЛИЙН БАГИЙН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ, ХҮСНЭГТЭЭР


(2023.04.27-ны өдрийн байдлаар)

Д/д	Үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт
1.	Бригадын ахлагчдад зуучилсан техникийн үнэлгээний захиалга	104
2.	Техникийн үнэлгээний захиалга хуваарилсан бригадын ахлагч	17
3.	Бригадын ахлагчдын хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээ	32
4.	Бригадын ахлагчдад зуучилсан дулаалгын ажил	1
5.	2-р элсэлтийн дадлагад гарсан бригадууд	16
6.	Бригадын ахлагчдад зориулж зохион байгуулсан сургалт, уулзалт, хурал, арга хэмжээ	7
7.	Дээрх сургалт, уулзалт, хурал, арга хэмжээнд оролцсон бригадын ахлагчид (давхардсан тоогоор)	145
8.	Арга зүйн зөвлөмж, туслалцаа үзүүлсэн бригадын ахлагч	17
9.	Техникийн үнэлгээ, дулаалга болон барилгын ажлын талаарх гарсан санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн харилцагч (давхардсан тоогоор)	90

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.3: БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛ


БҮАТЗХ-ийн “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн тайлан

БҮАТЗ-ийн хэлтэс нь 2023.04-р сард “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 800 гаруй ААНБ, иргэдийг тухай бүр мэдээллээр ханган ажиллав.






БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу барилгын тусгай зөвшөөрөл хүссэн 166 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, материалыг баталгаажуулж, Барилга, хот байгуулалтын яаманд 2023.04.06-ны өдөр, 2023.04.13-ны өдөр, 2023.04.20-ны өдөр, 2023.04.27-ны өдрүүдэд тус тус цахимаар илгээв.



2023.04 дүгээр сарын байдлаар давхардсан тоогоор 597 ААНБ-ын хүсэлт хянагдаж, 4 удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар 182 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Үүнээс сунгалтаар 25, нэмэлтээр 36, шинээр 118, дахин олгохоор 3 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулсан. Сунгалтаар 25 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас Барилга угсралтаар 21, Зураг төсөл боловсруулахаар 4, Нэмэлтээр 36 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас Барилга угсралтаар 31, Зураг төсөл боловсруулахаар 5, шинээр 118 ААНБ-ын хүсэлтийг хянаснаас Барилга угсралтаар 97, Зураг төсөл боловсруулахаар 20, Өргөх байгууламжаар 1, дахин олгохоор 3 ААНБ-ын хүсэлтийг хянаснаас Барилга угсралтаар 2, Өргөх байгууламжаар 1 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулсан байна. Эдгээр 4 удаагийн хурлаар давхардсан тоогоор 369 ААНБ-ын материалыг шаардлага хангаагүй учраас буцаав. 73 ААНБ-ын хүсэлт шалгагдахаар хүлээгдэж байна.



- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавих, барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 182 ААНБ-ын хүсэлтийн материалыг хянаж, 1,378 инженер, техникийн ажилтны баталгаажуулалтыг хийв.
- Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал”-д нийтлэх БҮАТЗ эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж БХБЯ-д хүргүүлсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газрын *opendata.burtgel.gov.mn* сайтад БУ: 4,330, ЗТ: 775, ӨБ-165 ААНБ-ын буюу нийт 5,270 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулсан.
- БҮАТЗ-тэй ААНБ-уудын мэдээллийн санг үүсгэн *www..mcis.gov.mn* сайтын “Холбогдох бичиг баримт хэсэг”-т нээлттэй байршуулсан бөгөөд БУ: 4,330, ЗТ: 775, ӨБ: 165 ААНБ-ын буюу нийт 5,270 ААНБ-ын мэдээллийг оруулсан.
- БХБ-ын Сайдын тушаалыг үндэслэн 221 ААНБ-тай гэрээ байгуулж, Засгийн газрын “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тогтоолын дагуу 224,920,000 төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг Худалдаа хөгжлийн банкны дансанд төвлөрүүлэв.
- 2023.04-р сард үйлчилгээний хөлсөнд 182 ААНБ-аас 109,340,000 төгрөгийг Худалдаа хөгжлийн банкны 431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.
- БХБ-ын Сайдын 2023.04.06-ны өдрийн №66 дугаар тушаал, 2023.04.10-ны өдрийн №69 дүгээр тушаал, 2023.04.24-ны өдрийн №83 дугаар тушаал, 2023.04.25-ны өдрийн №86 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн үнэт цаасанд бичилт хийж, баталгаажуулсан байна.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.4: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

Хүний нөөцийн чиглэлээр



“RADAR” менежмент ХХК-иас зохион байгуулсан “Чанарын удирдлагын ISO 9001:2015 олон улсын стандартын чанарын дотоод аудитор бэлтгэх сургалт”-д Үйл ажиллагаа хариуцсан менежер Х.Долзодмаа, Сургалт, судалгаа, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Ж.Бат-Эрдэнэ нар 2023.04.22-ны өдөр оролцов. Тус сургалтаар байгууллагадаа ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлэх арга зүй, түүний ач холбогдол, үр өгөөж, хэрхэн үйлчилгээний чанарыг тогтвортой, сайн болгох талаар онолын болон байгууллагуудын туршлагаас мэдээлэл өглөө. Мөн чанарын дотоод аудиторыг бэлтгэхэд ашиглах боломжтой загварууд, Европын болон АНУ-ын чанарын байгууллагаас гаргасан ISO 9001:2015 олон улсын стандарттай ижил төстэй, харьцуулж сонгох боломжтой менежментийн арга загварууд, Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх матрицын загварууд болон стандартын заавар зэрэг гарын авлагаар хангагдав. Энэхүү сургалтын үр дүнд байгууллагынхаа Чанарын менежментийн тогтолцооны матриц, удирдамжийг боловсруулаад байна.



2023.04.26-ны өдөр МҮХАҮТ-аас зохион байгуулсан “Бизнесийн ёс зүй ба комплеансын үндэсний II форум”-д БҮАТЗ-ийн Хэлтсийн дарга Х.Гүлбарша, Сургалт, судалгаа, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Ж.Бат-Эрдэнэ нар оролцов. Уг форумд бизнесийн ёс зүй ба хөдөлмөрийн харилцаа, “Оюу толгой” ХК-ийн сайн жишиг, бизнесийн ёс зүйн орчин ба хууль эрх зүйн өнөөгийн байдал зэргээр хэлэлцүүлэг явагдаж, үндсэн илтгэлүүдийн мэдээлэлтэй танилцав. Мөн энэ үеэр бизнесийн ёс зүйн сэдвээр зохион байгуулагдсан нийтлэлийн уралдааны шагнал гардуулах ёслолын ажиллагаа явагдав.



МБҮА ТББ-ын үйл ажиллагаа, барилгын тусгай зөвшөөрлийн цахим олголтын үйл ажиллагаатай танилцахаар Отгонтэнгэр их сургуулийн 18 оюутан Ажлын алба дээр хүрэлцэн ирж үйл ажиллагаатай танилцав.

Төрийн албан хаагчийн Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах журам, маягт өөрчлөгдсөнтэй уялдуулан Ажлын албаны 9 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, нийт албан хаагчдын 2023 оны ээлжийн амралтын хуваарийг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлав.

Судалгааны чиглэлээр:

Монголын барилгын салбарын ажиллах хүч, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг боловсруулж “IM IMPORTANT” арга хэмжээний ажлын хэсэгт хүргүүлж тус арга хэмжээний өдөр хананд байршуулах Барилгын салбар, мэргэжил, суралцагчтай холбоотой статистик мэдээллүүдэд оруулахаар боллоо. Мөн ШУТИС-ийн БАС-аас барилгын салбарын бакалаврын сургалтын суралцагч, төгсөгч, элсэлтийн тоон мэдээллийг авч байгууллагын судалгааг баяжуулав. МБҮА ТББ-ын бүхий л үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Чанарын удирдлагын хороо, дэд ажлын хэсгүүдийг томилж, байгууллагынхаа Чанарын бодлогыг тодорхойллоо.

IFAWPCA-ийн Дунд хугацааны чуулганы хүрээнд хийгдэж буй ажлууд:

– Ази, баруун номхон далайн Гэрээлэгчдийн ассоциациудын Олон улсын нийгэмлэг (IFAWPCA)-ийн 42 дахь удаагийн Дунд хугацааны чуулганыг зохион байгуулах бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна. Үүний хүрээнд (IFAWPCA)-тай онлайн уулзалт, Ерөнхий сайдын зөвлөх, БХБЯ-ны хэлстийн дарга Батзоригтай, ШУТИС-ын Барилга архитектурын сургуулийн ахлах багш, Доктор (PhD) Ц.Цоггэрэлтэй тус тус уулзалт хийж, чуулганы логог МБҮА ТББ-ын Гишүүн “Аниг” ХХК-ийн дэмжлэгтэйгээр бүтээж, чуулганы үеэр зохион байгуулагдах Олон улсын Форумын болон “Нээлттэй хаалганы өдөрлөг”, “B2B Бизнес уулзалт”, хэвлэл мэдээлэл, ТВ-ийн цацалт хийх танилцуулгыг боловсруулах зэрэг ажлын нарийвчилсан хөтөлбөр, зардлын тооцоо, чуулганд оролцохоор ирэх гадаад зочдын визний зөвшөөрлийг авах, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах албан бичгүүдийг боловсруулж хүргэх болон үүнтэй холбоотой уулзалтуудыг хийв. ТВ шторкны текстийг бэлэн болголоо.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2.6: САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ:

МБҮА ТББ-ын 04-р сарын байгууллагын өдөр тутмын гүйлгээ, ашиглалт, түрээс, интернэт болон бусад холбогдох төлбөрийг цаг тухайд нь төлж, “Дулаан шийдэл-2” төслийн сарын гүйлгээ болон дараа 03-р саруудын тайланг хийж дуусгаж, санхүүгийн программд холбогдох Журналын бичилт болон данс хоорондын төлбөр тооцоог тулган гүйлгээнүүдийг хийв. Мөн байгууллагын болон төслийн товлогдсон хурал уулзалтад оролцож, зөвлөмж чиглэлийг авч мөрдөн ажиллав. БҮАТЗ-ийн хураамж төлөлтийн дагуу И-баримтыг холбогдох компаниуд руу шивэв. Шаардлагатай компьютер, техник хэрэгслийн худалдан авалтыг хийв. 4-р улирлын НДШ тайлан, ХАОАТ болон НӨАТ-н тайланг гаргав.

МБҮА ТББ-ЫН 2022.04.30-НЫ ӨДРИЙН БАЙДЛЫН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ


Утга	Ажлын алба (₮)	БҮАТЗ (₮)
Харилцахын эхний үлдэгдэл	168,490,887.57	403,959,330.19
04-р сарын орлого	9,580,073.99	129,413,146.65
04-р сарын зардал	34,281,539.52	30,206,478.05
Харилцахын эцсийн үлдэгдэл	143,789,422.04	503,165,998.79

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.2: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

- МХАҮТ-д 2023.04.25-ны өдөр болсон “Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны барилгын шинэ дэвшилтэт технологийг баталгаажуулах, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж, санал боловсруулах уулзалт”-д зориулж гишүүн байгууллагуудаас Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны шинэ дэвшилтэт технологи, ногоон гэрчилгээ авахад тулгамдаж буй асуудлууд, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны стандартын өнөөгийн байдлын талаар ирүүлсэн саналуудыг нэгтгэн Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгаланд хүргэх албан бичгийг төлөвлөж танилцуулав.
- Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор ирсэн гомдол, албан бичигт хариуг төлөвлөж “Ж-108” СӨХ-д 2023.04.12-ны 23/32/АА тоотыг, “Ордос” ХХК-д 2023.04.11-ны 23/30/АА тоотыг, ЭЗХЯ-нд 2023.04.12-ны 23/251/ТЗ тоотыг, инженер Д.Уламбаяр-т 2023.04.04-ны 23/232/ТЗ тоотыг тус тус хүргэв.
- Удирдах зөвлөлийн 2023 оны анхдугаар хурлаар хэлэлцсэн татварын өртэй 20 байгууллагаас татвараа нөхөн төлөх асуудлыг нягтлан бодогчоор гүйцэтгүүлж, МБҮА ТББ-ын гишүүн компаниудын 2022 оны гишүүнчлэлийн татвараа төлөөгүйн улмаас саналын эрхийг нь 6 сараар түдгэлзүүлсэн 11 компаниудын нэрсийг эцэслэн гаргаж МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн хурлын 2023 оны 23/05 тоот тогтоолын Хавсралт 1-р албажуулан гаргав.
- “Барилгын тухай хуулийн хяналт, шинжилгээ үнэлгээ”-ний зөвлөх үйлчилгээний талаарх мэдээллийг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Төрийн худалдан авах ажиллагааны газраас лавласны дагуу танилцаж БХТ/202301362 дугаартай зөвлөх үйлчилгээнд МБҮА ТББ нь оролцох хүлтэй байгаа мэдүүлгийг 2023.04.07-ны өдрөөс өмнө Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр бүртгүүлэв.

➢ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.8: ТӨР-ХУВИЙН ХЭВШЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

2023.04.03: ТЕНДЕРИЙН ТУХАЙН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГАД БАРИЛГЫН САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР ТУСГАХ УУЛЗАЛТ БОЛЛОО



“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийн өргөтгөсөн хурал 2023.04.03-ны өдөр БХБЯ-нд болж тус хуульд тусгах барилгын салбарын зохицуулалт, зураг төсөл, барилгын материал эдлэлийн чанар, үнэ, стандартын хяналт, гэрээний хэрэгжилт, хариуцлагатай холбогдсон асуудлаар санал солилцож ярилцав. Тус хуралд УИХ-ын гишүүн, БХБ-ын сайд Ц.Даваасүрэн, УИХ-ын

гишүүн Ж.Батжаргал, УИХ-ын гишүүн Ц.Сандаг-очир, БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, БХБ-ын Сайдын зөвлөх н.Бат-Эрдэнэ, ББМҮБХЗГазрын дарга Д.Гантулга, мэргэжилтэн С.Должинсүрэн, Ажлын хэсгийн 10 гаруй гишүүд, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан, Ажлын албаны Салбарын бодлого хариуцсан Зөвлөх Г.Лосол нар оролцлоо. Хуралд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын боловсруулалтын талаар Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Барилга байгууламжийн чанарт нөлөөлөх хүчин зүйлийн талаар БХБЯ-ны ББМҮБХЗГазрын дарга Д.Гантулга нар мэдээлэл хийлээ. Тендерийн бичиг баримтын бэлтгэл зохион байгуулалтыг хангах, тендерийг үнэлж шалгаруулах, шалгарсан тендерийн явц, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах хүрээнд дараах асуудлуудыг зайлшгүй зохицуулах шаардлагатай байгааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга” болон “Барилгын тухай” хуулийн шинэчилсэн найруулга, бусад дагалдах хуулиудын төсөлд тусгахаар саналаа солилцлоо. Үүнд:

- Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тендертэй холбоотой асуудлыг бүх талаас нь судалж тусгах
- Барилгын зураг төсөлд тавих чанарын шаардлага, хариуцлагыг өндөр болгож, тухай барилга байгууламжид хэрэглэх материал, хийц эдлэл, тоноглолын сонголт, чанар, стандарт , код, шаардлагыг зураг төсөлд тодорхой зааж өгөх, түүнийг тендерийн үнэлгээний шалгуур болгон хэрэглэх, авторын хяналтыг сайжруулах
- Шинэ нэр төрлийн, үйлчилгээтэй барилгууд, төрөлжсөн /бассейн, спорт заал, сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэт/ барилга байгууламжид тавигдах тусгай шаардлага, үндсэн стандартыг тодорхой заасан нэг маягийн зураг төслийг баталж мөрдөх, түүнийг цаг үеийн хэрэгцээ, шаардлагаар сайжруулж байх
- Ямар тохиолдолд үнийн тодотгол хийхийг хуульд тодорхой зааж тусгах
- Барилгын ажлын явцад гүйцэтгэгч солих шаардлага гарвал түүнд хүлээлгэх хариуцлага, торгууль , хохирлын асуудлыг хамт шийддэг байх
- Дахин магадлал хийх, эсвэл магадлал хийхгүйгээр үнийн инфляцын дагуу төсвийн өөрчлөлт хийх асуудлыг сайн судалж, асуудлыг зөвөөр шийдэх
- Үнийн индексийг баталж санхүүжилт, гүйцэтгэлээ баталгаажуулахад хэрэглэх боломжийг судлах
- Хэдэн жилийн өмнө хийгдсэн зураг төсөл хэрэглэх тохиолдолд түүнд дахин иж бүрэн магадлал заавал хийдэг болох/ одоо зөвхөн үнэ, төсвөө л өөрчилдөг/
- Урьдчилгаа төлбөрийн 30 хувь олгохоор тендерийн бичиг баримтад тусгасан бол түүнийг заавал олгодог болох
- Чанаргүй хийсэн зураг төсөлд өөрчлөлт оруулж, нэмэлт санхүүжилт авдаг асуудалд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж гарсан хохирлыг хэн төлөхийг тодорхой хуульчилж өгөх
- Зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт техникийн нөхцөл, суурь судалгаа, хэрэглэх материал, тоноглолын стандарт, кодыг тодорхой зааж өгч, зураг төслийн чанарт тавих шаардлагыг сайжруулах
- Гүйцэтгэгч тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа төлж, банкны зээл авч, ажлаа тасралтгүй төлөвлөсөн байхад тухайн объектыг төсвийн тодотголоор хасвал учрах хохирлыг компани хариуцахгүй, Сангийн яам хариуцдаг болох зэрэг асуудлыг хуулийн

төсөл боловсруулж байгаа хоёр Ажлын хэсэг хамтран дахин нарийвчлан ярилцаж, аль хуульд ямар өөрчлөлт, шинэчлэлт оруулах саналаа тохирохоор болов.

2023.04.03: ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСӨЛД ХЭРХЭН ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛААР УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МБҮА ТББ нь 2020-2024 онд хэрэгжүүлэх “Стратеги төлөвлөгөө”-дөө бүтээн байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх төслүүдийн нэг нь “Гэр хорооллын дахин төлөвлөлт” байгаа бөгөөд уг төслийг хэрэгжүүлэх хүрээнд “Монголын хот байгуулалтын холбоо”-ны Тэргүүн, “Гудамж” төслийн Захирал асан (Доктор PhD) Б.Батболд болон төслийн багийнхантай 2023.04.03-ны өдөр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Гүйцэтгэх захирал Л.Хулан, “Би Ди Эм Ти” ХХК-ийн захирал Ш.Мөнхсайхан, “Стратеги, бодлогын зөвлөх нэгж”-ийн Дарга Ц.Өнөржаргал болон Ажлын албаны ажилтнууд оролцон гэр хорооллын дахин төлөвлөлт, бүтээн байгуулалтад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд өөрсдийн хэрэгжүүлсэн туршлагаа хуваалцахаас гадна төслийн өнөөгийн хийгдсэн ажлууд болон хийгдэхээр төлөвлөж буй ажлуудыг танилцуулж, улмаар уг төсөл хөтөлбөр дээр хэрхэн хамтран ажиллах боломж бололцоо байгаа талаар талууд санал бодлоо солилцлоо. юм.

2023.04.04: БАРИЛГЫН АЖЛЫН ЯВЦАД ХАБ-ЫН АЖИЛТНААС ГАДНА БАЙГУУЛЛАГА, ХУВЬ ХҮН БҮГД ХАРИУЦЛАГАТАЙ БАЙНА



Барилга, хот байгуулалтын яамнаас улсын хэмжээнд өргөх байгууламжийн хууль тогтоомж, норм, дүрмийг хэрэгжүүлж буй байдал, болзошгүй осол аваараас урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангуулах зорилгын дор мэргэжлийн болон ашиглагч байгууллагуудын дунд **“ӨРГӨХ БАЙГУУЛАМЖИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ СТАНДАРТ”** сэдэвт зөвлөгөөнийг 2023.04.04-ны өдөр зохион байгуулагдлаа. БХБЯ-ны салбарын хяналтын газар нь өргөх байгууламжуудын үйл ажиллагаа нь ашиглалтын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгахад илэрч буй зөрчлүүд, норм, дүрмийг хангуулаагүй байдал зэрэгт үнэлэлт дүгнэлтийг хийж, улмаар зөрчилтэй байдлыг арилгуулах чиглэлийн хүрээнд мэдээлэл, зөвлөмжийг өгч, хэлэлцүүлгийг өрнүүлэв. Улсын хэмжээнд 19,230 өргөх байгууламж бүртгэлтэй байгаагийн 81.5% нь буюу 15,671 нь нийслэлд ашиглагдаж байна. Орон нутагт 18.5% буюу 3,559 өргөх байгууламжийг ашиглаж байна. Орон сууцны хэрэгцээнд



нийт 8,131 лифт ашиглагдаж байгаагаас 323 лифт нь эрсдэлтэй гэж дүгнэгджээ. Эрсдэл өндөртэй нийт лифтний 89% нь буюу 289 лифт нь нийтийн орон сууцанд, 34 лифт нь эмнэлгийн байгууллагад ашиглагдаж байгаа тул яаралтай арга хэмжээг авч ажиллах шаардлага тулгарч байна. Шалгалтын явцад *лифтний хонгилын хаалга тохиргоогүй, мэргэжлийн лифтчин байхгүй, засвар үйлчилгээний байгууллагатай гэрээ байгуулаагүй, ээлжит магадлалд хамрагдаагүй, лифтний түргэн элэгддэг эд ангиудыг шинэчлээгүй* зэрэг зөрчлүүд түгээмэл илэрч байгаа гэсэн байна. Шаардлага хангахгүй гэж дүгнэгдсэн лифтнүүдээс 132 лифтний ашиглалтын хугацаа нь дууссан байснаас шинэчлэн солих, эвдрэлтэй лифтний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр заавар зөвлөмжийг өглөө. Харин *краны үйл ажиллагааны хувьд ослоос урьдчилан хамгаалах хэрэгсэл ажиллахгүй байх, засвар үйлчилгээ хийлгээгүй, оосорлогч, дохиочин зэрэг мэргэжлийн ажилтан ажиллуулаагүй* зэрэг зөрчлүүд илэрч байгаа тул дээрх бүх зөрчлийг арилгах чиглэлд хамтарч ажиллах талаар оролцогч байгууллагууд санал солилцлоо. Өргөх байгууламж болох лифт, краны аюулгүй ажиллагааг хангах зорилготой энэхүү зөвлөгөөнд БХБЯ, ХНХЯ, МБҮА ТББ, орон сууцны лифт ашиглагч байгууллагууд, өргөх байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн төлөөллүүд оролцов. Тус зөвлөгөөнд МБҮА ТББ-ын Ажлын албаны БҮАТЗ-ийн хэлтсийн дарга Х.Гүлбарша нь “Өргөх байгууламжийн тусгай зөвшөөрлийг цахимаар гаргах зааварчилгаа” сэдвээр танилцуулга хийж, барилгын салбарын нэгдсэн систем, түүний модуль болох барилгын тусгай зөвшөөрлийн цахим системийн талаар мэдээ, мэдээллийг өгөв.

2023.04.06: “БАРИЛГЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЧУУЛГАН”-Д ОРОЛЦОЖ БАЙР СУУРИА ИЛЭРХИЙЛЛЭЭ













Барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааг танилцуулах, дэмжих зорилгоор “Барилгын ханган нийлүүлэгчдийн чуулган”-ыг 2023.04.06-ны өдөр барилгын салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран МҮХАҮТ-д зохион байгуулагдлаа. “Барилгын ханган нийлүүлэгчдийн чуулган”-ы үеэр “Дотоодын барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж”, “Орчин үеийн ханган нийлүүлэлтийн тогтолцоо” сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнөсөн ба төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллүүдийн илтгэл, хэлэлцүүлэг явагдаж, түүнээс гарсан дүгнэлтийг төрийн байгууллага болон шаардлагатай газруудад хүргүүлэн, гарц шийдлийг тодорхойлохоор боллоо.

2023.04.11: МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ОПЕРАТОРУУДЫН АССОЦИАЦИ-Д МБҮА ТББ МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ

Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдсанаар салбарын бодлогууд шинэчлэгдэж улмаар цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг үйлчилгээг хүргэх зорилгоор айл өрх, барилгын өрөө тасалгаа хүртэл шилэн кабелийн технологийг нэвтрүүлэх бодлого гаргасан. Энэ технологийг барилгын зарим компаниуд IPTV, интернэтийн компаниудтай хамтраад нэвтрүүлээд эхэлсэн бөгөөд сүүлийн үеийн зарим хотхон, оффис барилгууд барилгын доторх үйлчилгээг автоматжуулах, ус, цахилгаан, дулааныг хянах, дохиоллын системүүдийг нэгтгэсэн Барилгын менежментийн систем (БМС)-ийг нэвтрүүлж байгаа. Мэдээлэл Холбооны Операторуудын Ассоциаци ТББ нь 2019 оноос Барилгын холбоо, дохиоллын норм ба дүрмийг боловсруулж, экспертүүдийн дүгнэлт, шүүмжээр орж, БХТ-ийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021.04-р сард хэлэлцүүлэн батлуулсан. Улмаар 2022.03-р сард БХБЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, нэмэлт өөрчлөлтүүдийг хийж хуралд дахин оруулах шийдвэр гарсан ч өнөөдрийг хүртэл тодорхой шийдэлд хүрээгүй байна. Тус ТББ нь МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулантай уулзаж тус нормыг батлуулахад барилгын чиглэлийн ТББ-ын зүгээс дэмжлэг, туслалцаа, зөвлөгөө хүссэний дагуу холбогдох мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласнаар 2023.04.25-ны өдөр БХБЯ-ны ШУТЗ-ийн хурлаар уг норм батлагдлаа. Дашрамд дурдахад, Мэдээлэл Холбооны Операторуудын Ассоциаци ТББ-ын бүрэлдэхүүнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Скайнэтворкс ХХК, Монгол шуудан ХК зэрэг харилцаа холбооны хөрөнгө оруулалт, зах зээлийн 80 гаруй хувийг эзэлдэг компаниуд гишүүнээр байдаг юм байна.

2023.04.25: ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ШИНЭ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, ЭРЧИМЖҮҮЛЭХ УУЛЗАЛТ БОЛЛОО




Монгол Улсын Сайд, ЗГХЭГ-ын Дарга Д.Амарбаясгалан-ын санаачилгаар “ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН ШИНЭ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ СУДАЛЖ, САНАЛ БОЛОВСРУУЛАХ УУЛЗАЛТ”-ыг 2023.04.25-ны өдөр МХАҮТ-д зохион байгуулагдлаа. Санал солилцох уулзалтад МБҮА ТББ-ын Дэд Ерөнхийлөгч Б.Чимэгцэцэг, Гүйцэтгэх захирал Л.Хулан, Үйл ажиллагаа хариуцсан менежер Х.Долзодмаа болон гишүүн 25 байгууллагын төлөөллүүд оролцож, уулзалтаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

- Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны шинэ дэвшилтэт технологи манай оронд хийгдэж буй шийдлүүд
- Ногоон гэрчилгээ авахад тулгамдаж буй асуудлууд
- Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны стандартын өнөөгийн байдал

МБҮА ТББ-ын зүгээс саналуудаа нэгтгэн Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд албан бичгээр хүргүүлэв.

2023.04.20: “УЛААНБААТАР-ОЛОН УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТҮНШЛЭЛИЙН ФОРУМ”-Д ОРОЛЦОВ



Нийслэл хотын эдийн засгийг эрчимжүүлж, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагаас хөрөнгө оруулалт татах зорилгоор “Улаанбаатар-Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум”-ыг 2023.04.20-ны өдөр нийслэлийн Засаг захиргааны шинэ байр (Яармаг)-нд зохион байгууллаа.Энэ удаагийн форумыг Улаанбаатар хотын томоохон бүтээн байгуулалтад хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэн хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд хөрөнгө оруулалт шаардлагатай төрийн болон хувийн хэвшлийн 40 гаруй төсөл, хөтөлбөрүүдийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад сурталчлав. Түүнчлэн, нийслэлийн зүгээс түншлэгч байгууллагуудтай харилцан шийдэлд хүрсэн төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд санамж бичиг, хамтран ажиллах гэрээ зэргийг байгуулав. “Улаанбаатар-Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум 2023” үйл ажиллагааг зохион байгуулж байна. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Улаанбаатар хотын Шинэ сэргэлтийн бодлогын талаар илтгэлд дурдсанаар 2030 онд:

- *ДНБ нь 120-150 их наяд төгрөгт хүрнэ*
- *1 хүнд ногдох ДНБ нь 1,2054 ам.доллар болно*
- *Ядуурлын түвшнийг 15 хувиар бууруулна гэж онцоллоо.*

2023.04.25: “ПОЛЬШ-МОНГОЛЫН БИЗНЕС ФОРУМ”



Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Анджей Дудагийн Монгол Улсад хийж буй айлчлалын хүрээнд Монгол-Польшийн бизнес форум нь 2023.04.25-нд болсон бөгөөд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан тус форумд оролцож хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн боломжуудын талаар мэдээ мэдээлэл авлаа. Форумыг МҮХАҮТ, БНПольш Улсын Хөрөнгө оруулалт, худалдааны агентлаг, Монгол Улсын Гадаад харилцааны яам, Польш Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам хамтран зохион байгуулсан бөгөөд арга хэмжээнд Польш Улсын сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, эрүүл мэнд, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээлэл технологи, цахилгаан эрчим хүч, барилга, аялал жуулчлал зэрэг салбарын 20 компани оролцсон бол Монголын талаас 300 орчим бизнес эрхлэгч, ААН-ийн төлөөлөл оролцлоо. Мөн хоёр талын бусад холбогдох байгууллагуудын төлөөллүүд Монгол, Польшийн бизнесийн орчин, худалдааны боломжууд, тээвэр логистик, хөдөө аж ахуйн салбарын экспорт импорт, хамтарсан үйлдвэрлэл, Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, Польш-Монголын

хөрөнгө оруулалтын боломжууд, банк санхүү зэрэг сэдвүүдээр илтгэл тавьж, мэдээлэл өгөв. Монгол Улсаас Польш Улс руу 2022 оны байдлаар 599 мянган ам.долларын өртөг бүхий тун хэлбэрт савлагдсан эмүүд, бүх төрлийн оёмол, сүлжмэл хувцас, бараа зэргийг экспортоор гаргасан бол Польш Улсаас 97.7 сая ам долларын өртөг бүхий алим, лийр, лаазалсан ногоо, жимс, самар, шоколад ба какао агуулсан хүнсний зүйлс, тун хэлбэрт савлагдсан эмүүд, согтууруулах биш ундаа, ариун цэврийн болон нүүр, хумс заслын бэлдмэл, гахайн мах, гахай, шувууны өөх зэрэг бүтээгдэхүүн импортолжээ. Хоёр орны худалдааны эргэлт сүүлийн гурван жилийн хугацаанд хоёр дахин нэмэгдсэн байна.





ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 3.6: ОЛОН УЛСЫН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИДЭВХЖҮҮЛЭХ

2023.04.17-22: “BAU 2023” ҮЗЭСГЭЛЭН, ЯАРМАГТ МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД ОРОЛЦЛОО

ХБНГУ-ын архитектур, материалын дэлхийн тэргүүлэгч **“BAU 2023”** үзэсгэлэн яармаг нь 2023.04.17-22-ны өдрүүдэд **Мюнхен хотын Messe München** үзэсгэлэнгийн төвд зохион байгуулагдлаа. Европын Холбооны барилгын салбарын хамгийн том тус үзэсгэлэнд барилгын салбарын холбоод, нийгэмлэгүүд, дизайнер, архитекторууд, хөрөнгө оруулагчид, аж үйлдвэр, худалдааны салбарын төлөөлөгчид цуглардаг бөгөөд тус үзэсгэлэнд МБҮА ТББ-ын гишүүн компаниуд буюу “Эн Ар” ХХК, “Бүрэн Одод” ХХК, “Инвескор” ХХК, “Бульдорс Мон” ХХК, “Сүндэр өргөө трейд” ХХК зэрэг компаниудын төлөөлөгчид болон МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Л.Хулан нар оролцсон бөгөөд үзэсгэлэнгийн үеэр барилгын шинэ техник технологи, бараа бүтээгдэхүүнтэй танилцлаа. Уг үзэсгэлэнгийн үеэр МБҮА ТББ-ын Гишүүн байгууллагууд Архитектурын үйлчилгээ, барилгын засвар үйлчилгээ, барилгын менежмент, барилгын аюулгүй байдал, барилгын төлөвлөлт, зөвлөгөө, шал, дулаалга, дулаалгын материал, интерьер дизайн, барилгын материал, төслийн менежмент, төсөл төлөвлөлт, нарны хавтан, смарт технологи, ногоон барилга, эко хаус, пассив барилга гэсэн чиглэлүүдээр танилцлаа. Улмаар “Бульдорс Мон” ХХК нь Герман улсын хаалга үйлдвэрлэлийн компани “Moselturen” LLC, “Lebo Doors” LLC-тай, “Эн Ар” ХХК нь интерьер дизайны компани болох “Caparol” LLC, акустик хана болон таазны панел үйлдвэрлэгч Odean LLC, металл, мод, хуванцар гэх мэт материалуудыг боловсруулагч “Nugel” LLC, агаар сэлгэлтэй фасад үйлдвэрлэгч борооны

ус зайлуулах үйлдвэрлэгч “Graf” LLC-тай, “Инвескор” ХХК нь хаалга, цонхны татуургын компани “GEZE” LLC-тай, “Сүндэр өргөө трейд” ХХК нь бетон дүүргэгч үйлдвэрлэгч компани болох “Cobiax” LLC, хөөсөн дулаалгатай гоёлын цементэн хавтан үйлдвэрлэгч “Terasun LLC компаниудтай уулзаж зах зээлийн төлөв байдал, хэрхэн хамтран ажиллах талаар ажил хэргийн уулзалт хийж санал бодлоо солилцлоо







ТУРК: ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ДАРААХ ТУРК УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



Турк улсад болсон газар хөдлөлтийн дараа тус улсын Засгийн газар нэг жилийн хугацаанд газар хөдлөлтөд нэрвэгдсэн бүс нутагт нийт 488,000 орон сууц барих төлөвлөгөө баталсан ба тус төлөвлөгөөг Байгаль орчин, хот байгуулалт, уур амьсгалын өөрчлөлтийн яам хариуцаж ажиллахаар болоод байна. Мөн тус бүтээн байгуулалтын ажилд Туркийн Орон сууцны хороолол агентлаг оролцох юм байна. Түүнээс гадна газар хөдлөлтөд хөндөгдөөгүй туннелийн суурь, барилга бүтээцийг судлаад үзэхэд уг туннел нь хэв хашмалын системийг ашиглан баригдсан байсан бөгөөд энэ нь газар хөдлөлтийн өндөр эрсдэлтэй газруудад сайн тэсвэртэй байдгийг олж тогтоосон байна. Энэ удаагийн бүтээн байгуулалтын төлөвлөлтөд Туркийн Засгийн газар геологи, геодезийн судалгааг чухалчлан үзэж нурсан байшингуудыг сэргээн босгох, шинээр барих зэрэгт ашиглахаа чухалчилж үзээд байна.

АНУ: БАРИЛГЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ ХҮНДРЭЛТЭЙ ХЭВЭЭР БАЙНА



Барилгын салбарын тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид COVID-19 тахлын нөлөөнөөс гурван жилийн дараа сэргэх үйл явц ажиглагдаж байна. Тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн холбоо (AEM) нь гишүүдээсээ бизнесийн сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авдаг бөгөөд сүүлд хийсэн судалгаагаар судалгаанд оролцогчдын дийлэнх нь цар тахлын дараа ч нийлүүлэлтийн сүлжээний асуудалтай тулгарч байна гэсэн хариу

өгсөн бөгөөд нөхцөл байдал улам дордсоор байгааг дурдсан байна. “Global Data” компанийн барилгын ахлах эдийн засагч, Дэнни Ричардс барилгын салбарын тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид зориулж таамаг гаргасан ба Үүнд: Дэд бүтэц, эрчим хүч, нийтийн аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийх нь өсөлтийн хөдөлгөгч хүч байх болно. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт, ялангуяа АНУ-ын Хөрөнгө оруулалтын дэд бүтэц, ажлын байрны тухай хууль хүчээ авч байгаа энэ үед өсөлтийн хөшүүрэг хэвээр байх болно. Мөн эрчим хүч, нийтийн аж ахуй нь барилгын нийт үйл ажиллагааг идэвхжүүлж, сэргээгдэх эрчим хүчний төслүүд хөрөнгө оруулалтын гол чиглэл хэвээр байх болно.

АНУ: БАРИЛГЫН ШИНЭ ШИЙДЭЛ, ЦАХИЛГААН ЭКСКАВАТОР



Барилгын ажил гэдэг цаг хугацаа, мөнгө, зогсолтгүй эргэх хүч байдаг бөгөөд ажил хөнгөвчлөх, барилгын угсралтад хамгийн гол түлхэц үзүүлдэг техник бол “JCB”-ын цахилгаан экскаватор билээ. Хэдийгээр уг экскаваторын хүчин чадал үнэ цэнтэй байгаа ч батарейг нь цэнэглэх хугацаа нэг өдрийн ажлыг алдагдуулж байгаа нь жижиг ажлын талбай дээр найман цаг тасралтгүй ажиллах боломжгүй гэж зарим компаниуд үзэж байна. Гэсэн хэдий ч үйлдвэрлэгчид дээрх саналыг үл харгалзан шинэ цахилгаан экскаваторуудыг бүтээхдээ тогтвортой байдал болон түлшний хэмнэлт гэсэн үндсэн зорилгод анхаарлаа хандуулах болжээ. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэгчид экскаваторын инженерчлэл, бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг хийхдээ агаарын бохирдол үүсгэхгүй байх тал дээр илүү анхаарал хандуулж цахилгаан болон өөр түлшээр цэнэглэгддэг байдал дээр шинэчлэл хийж эхэлжээ.

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ
Монгол Улс, Улаанбаатар 15141
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

+(976) 70111515, 94444173

info@mnca.mn

www.mnca.mn